БАТЛАВ:

ЗАСАГ ДАРГА: У.АЛТАНХҮҮ

# ӨНДӨРШИЛ СУМАНД УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР , НЭГ ЗАГВАРЫН ЗУРАГ ТӨСВӨӨР БАРИГДАХ 10 ОРТОЙ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН БАРИЛГА , ЭМЧИЙН БАЙРНЫ ЗУРГИЙН ДААЛГАВАР

2023.05.10 Бөхт

| | | |
|---|---|---|
| 1 | Зураг төсөл боловсруулах үндэслэл | Өндөршил сумын Засаг даргын 2020-2024 оны ҮАХ-ийн Дэд бүтцийн хөгжил бүлгийн 1.1.5 дахь заалт |
| 2 | Ажлын нэр байршил | “ ЭМТ-ийн барилга“ , “Эмчийн байрны барилга” Бөхт” багийн төвд |
| 3 | Захиалагч байгууллага | Өндөршил сумын ЗДТГ ,ЭМТ |
| 4 | Зориулалт хүчин чадал | Сумын хүн амын эрүүл мэндийн тусламж , үйлчилгээний чанар , хүртээмж , орчин нөхцлийг сайжруулах , стандартын шаардлагад нийцсэн 10 ортой ЭМТ-ийн барилга, эмчийн амьдрах байрыг шинээр барих |
| 5 | Төслийн хүрээнд хийгдэх ажлын бүтэц | Ерөнхий төлөвлөгөө<br>• БХБЯ, ЭМЯ -ны захиалгаар “Хот төлөвлөлт , судалгааны институт” ОНӨААТҮГ-ын боловсруулсан /ЕГ Шифр: ХТСИ -04-21 / , 2021 онд гүйцэтгэгдэж Барилгын Хөгжлийн Төв 234/2021 дугаартайгаар магадлал хийгдсэн “ 10 ортой нэг маягийн эмнэлгийн барилга” зургийн дагуу баригдана<br>• ЭМТ-ийн барилгын гадна дулааны шугамыг төв магистрал шугамаас “ Ирмүүн түшиг” ХХК-аас олгосон техникийн нөхцлийн дагуу 66 м -ээс авах.<br>• Цэвэр усны шугамыг 32 м -ээс хуучин барилгын баруун урд худгаас татах<br>• Бохирын цооногийг барилгын зүүн урд талд 50 м3-ийн багтаамжтайгаар төлөвлөж 15м шугам татах |

| | | |
|---|---|---|
| | | • Цэвэр усны шугамтай хамт дулааны шугамыг хуучин барилгын баруун урд талын худа 13 м зайд татах<br>• Эмчийн барилгын гадна дулааныг ЭМТ-ийн шугамнаас 10м -т татах<br>• Эмчийн байрны цэвэр усны шугам хуучин барилгын баруун урд худгаас 44 м -т татах<br>• Эмчийн байранд бохирын цооног 10м3 багтаамжтайгаар барилгын баруун урд талд төлөвлөж, 5 м шугам татах<br>• Барилгын гаднах явган хүний зам , автомашины зогсоол , ногоон байгууламжийг зурагт төлөвлөгдсөн хэмжээгээр төлөвлөх<br>• ЭМТ-ийн барилга , эмчийн байрыг явган хүний замаар холбох<br>• Гадна хашааг төлөвлөх<br>• Цахилгааныг техникийн нөхцлийн дагуу<br>• Холбооны сүлжээг техникийн нөхцлийн дагуу<br>• Цэвэр усыг техникийн нөхцлийн дагуу<br>• Цэвэр усны нөөцийн сав , шийдлийг төлөвлөх |
| 6 | Тавигдах шаардлага | • Олон нийтийн зориулалттай байгууламж учир бат бөх хийцтэй байна.<br>• Зургийн даалгаврын дагуу газар дээр нь нягталж төлөвлөх |
| 7 | Санхүүгийн эх үүсвэр | Улсын төсвийн санхүүжилтээр . 16 сая. төг |
| 8 | Төслийн хэрэгжих үе шат, хугацаа | Төсөл 1 үе шаттай хэрэгжинэ. Зураг төсөл боловсруулах ажил мөн 1 үе шаттай. Гэрээнд заасан хугацаанд. |
| 9 | Захиалагчийн нэр , хаяг, утасны дугаар | Өндөршил сумын ЗДТГ. Бөхт баг. Утасны дугаар: 88822284, 88860996, 88206121 |

Төлөвлөлт хийсэн : ЗДО Л.Мөнхбадрах

БАТЛАВ

ЗАСАГ ДАРГА-Д У.АЛТАНХҮҮ

# ДУНДГОВЬ АЙМГИЙН ӨНДӨРШИЛ СУМАНД ШИНЭЭР БАРИГДАХ 10 ОРТОЙ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН БАРИЛГА, ЭМЧИЙН БАЙРНЫ БАЙРШЛЫН ЭСКИЗ ЗУРАГ




Зураг үйлдсэн:

Газрын даамал Б.Нарандэлгэр

БАТЛАВ

ДУНДГОВЬ АЙМАГ/НИЙСЛЭЛ/-ИЙН ЕРӨНХИЙ АРХИТЕКТОР ...../Э.ЭНХМЭНД/

ДУНДГОВЬ АЙМГИЙН ЕРӨНХИЙ АРХИТЕКТОР ЕА 12

# АРХИТЕКТУР ТӨЛӨВЛӨЛТИЙН ДААЛГАВАР

Дугаар АТД-48-38/23

2023 оны 05 сарын 09 12:19:-ны өдөр

Өндөршил

| | |
|---|---|
| **Үндэслэл** | Дундговь аймгийн Өндөршил сумын Засаг даргын 2023 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 04831-А/42/2023 дугаар захирамж, Өндөршил сумын 3-р баг Төв гудамж, 113 тоот хаягт байршилтай Эрүүл мэндийн байгууллагын зориулалтаар олгосон 4801000808 нэгж талбарын дугаартай газар олгот, Дундговь аймгийн Өндөршил сумын Засаг даргын 2023 оны 05 дүгээр сарын 09-ны өдрийн хүсэлтийг тус тус үндэслэв; |
| **1. Барилга байгууламжийн байршил тогтоосон газар олголтын захирамжийн дугаар, олгогдсон газрийн байршил, хэмжээ** | Дундговь аймгийн/нийслэл/ Өндөршил Сумын Засаг даргын захирамж -н 2023-04-20-нд, 04831-А/42/2023 тоот захирамжаар Өндөршил сумын/дүүрэг/ 3-р баг, Бөхт, Эрүүл мэндийн байгууллаганий эзэмших зориулалтаар 2159 м2 газрыг 60 жилийн хугацаатай эзэмшүүлсэн. |
| **2. Барилга байгууламжийн нэр, зориулалт, хүчин чадал, хүчин чадлын нэгж** | Өндөршил сумын Эрүүл мэндийн төвийн барилга, Төрөл бүрийн зориулалттай олон нийтийн барилга, 10 ортой, |
| **3. Барилгажих талбай / төлөвлөлтийн талбайгаар/** | 653.05 м.кв |
| **4. Барилгын төрөл, давхрын тоо** | Эрүүд мэндийн, 2 давхар |
| **5. Дагаж мөрдөх ерөнхий төлөвлөгөө** | "Хот байгуулалтын тухай хууль", "Барилгын тухай хууль" болон бусад хууль, холбогдох барилгын норм ба дүрмүүдийг мөрдлөг болгох. |
| **6. Ерөнхий төлөвлөгөөний бүсчлэл** | Орон сууц, олон нийтийн бүс; |
| **7. Эдэлбэр газар** | 2159 м2 |

Үүнээс:

- Барилгажих талбай: **1511**- Эдэлбэр газрын 70%-аас илүүгүй /ХБТХууль 12.8/, "Хот тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм дүрэм" БНБД30-01-04-ийг баримтлан төлөвлөх;
- Ногоон байгууламж, зам талбай: **648**- Эдэлбэр газрын 30%-аас доошгүй /ХБТХууль 12.6.3/;
- Авто зогсоол: "Авто зогсоол" БНбД 21-05-10-ийн дагуу автомашины зогсоол, авто зам төлөвлөх;
- Бусад:

| | |
|---|---|
| **8. Барилгажилтын улаан шугамын зай** | Магадлал хийлгэсэн ажлын зургийн дагуу барилгын тэг тэнхлэг тавиулж, барилгын ажлыг холбогдох зөвшөөрөл авсны дагуу эхлүүлэх; |
| **9. Талбайн ерөнхий төлөвлөгөө, тохижилтод тавигдах шаардлага** | "Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм" /БНбД 30-01-04/, "Эмнэлгийн барилга" /БД 31-115-12/, "Олон нийт иргэний барилга" БНбД 31-03-03, "Эрүүл мэндийн байгууллагын орчны эрүүл ахуйн шаардлага" /MNS 6392:2013/ стандартыг баримтлах. Орчны барилга байгууламжтай уялдуулж ногоон байгууламж төлөвлөх, зам талбайд гэрэлтүүлэг хийж, гадна тохижилтын зургийг иж бүрэн боловсруулах; |
| **10. Талбайн өндөржилтөд тавигдах шаардлага** | Гадаргуугийн ус зайлуулах арга хэмжээг эдэлбэр газрын хэмжээнд тухайн орчны газрын гадаргуутай уялдуулан шийдвэрлэж, ажлын зураг тусгах; |
| **11. Архитектур төлөвлөлтийн шаардлага** | Архитектур төлөвлөлтөд онцгой анхаарч, барилгын нүүр талуудыг /фасад/ тухайн орчиндоо өнгө үзэмж нэмхүйц шийдлийг сонгон, галын аюулгүй байдлыг БНбД 21-07-14-ийг ханган төлөвлөх. Орчны барилгуудтай уялдуулан "Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм" БНбД 30-01-04-ийн 2.11, 9.19 дэх заалт болон "Орон сууц, олон нийтийн барилгын байгалийн гэрэлтүүлэг" БД31-112-11, "Орон сууц, олон нийтийн барилга, сууцны барилгажилтын бүсийн нарны /зэвэрлэлтийн/ хангамж БНбД 23-04-07, бусад норм дүрмийн холбогдох заалтыг баримтлан төлөвлөх. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн орц, гарц пандусыг MNS 6055:2009, MNS 6056:2009 стандарт, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдрах орчны шаардлагад нийцсэн зураг төсөл зохиох норм БД 31-112-11-ийн дагуу төлөвлөх Тус барилгыг хавтгай дээвэртэй төлөвлөх бол эдэлгээний хугацаа 20 жилээс багагүй унифлекс ЭКП, ЭПП ус тусгаарлах дээврийн хуйлмал материал болон түүнтэй дүйцэхүйц ба илүү эдэлгээтэй материал сонгох; |
| **12. Инженерийн шугам сүлжээнд тавигдах шаардлага** | Инженерийн шугам сүлжээний хамгаалалтын зурвас, норм дүрэм стандартыг баримтлан төлөвлөх; Төвлөрсөн шугам сүлжээнд холбогдохоор өгөгдсөн техникийн нөхцөлийн дагуу гадна шугам, сүлжээний зураг төслийг боловсруулж мэргэжлийн байгууллагаар хянуулан зөвшилцөх; Хэрэглээний халуун усны шугам төлөвлөх, халаах хэрэгслийг М-140 маркийн ширмэн радиатор сонгох; |
| **13. Инженерийн бэлтгэл арга хэмжээ (үерийн хамгаалалт, далан, суваг, шуудуу, зайлуулах шугам сүлжээ)** | Эдэлбэр газарт газрын зураглалын тодруулалт хийлгэж зураг төслийг боловсруулах. Барилгын ажлын явцад эвдэлсэн зам талбай, ногоон байгууламжийг нөхөн сэргээх, инженерийн шугам сүлжээг шилжүүлэх зардлыг төсөвт тусгах; |

| | |
|---|---|
| **14. Захиалагчийн нэр, хаяг, утас** | • Хуулийн этгээдийн оноосон нэр: Дундговь аймгийн Өндөршил сумын эрүүл мэндийн төв<br>• Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар: 9033203<br>• Холбоо барих утас: 88206121<br>• Цахим шуудан: doyoderdenechuluun@gmail.com<br>• Хаяг: Дундговь аймаг, Өндөршил сум 3-р баг , Төв 111 |
| **15. Хот төлөвлөлтийн онцгой нөхцөл** | Барилгын ажлын талбайн зохион байгуулалтын зургийг зураг төсөлд хавсаргах. Одоо байгаа барилга байгууламжийн ашиглалтын хэвийн, аюулгүй байдлыг ханган барилгажуулах. Онцгой байдлын үед гал унтраах, аврах баг бүрэлдэхүүн саадгүй ажиллах боломжтой төлөвлөх. Барилгажих хэсгийг барилгажилтын шугамаас хэтрүүлэхгүй, авто болон явган замын хөдөлгөөний урсгалыг оновчтой төлөвлөх. Газар хөдлөлийн 6 баллд төсөллөх; |

**Онцгой нөхцөлд:**

- Барилга барих явцад хүрээлэн буй орчны байгалийн тогтоц, өмнө хийгдсэн тохижилт, зам талбай, ногоон байгууламжийг хамгаалах ба хэрэв хөндвөл нөхөн сэргээх.
- Өндөр барилгын бүсчлэлд талбайн хэмжээнд микросейсмикийн үнэлгээ гаргуулах, цогцолбор барилгын инженерийн хангамж, шугам сүлжээ, дэд бүтцийн техникийн нэгдсэн шийдлийг шийдвэрлэх.
- Хуучин барилга, байгууламжийг зайлшгүй буулгах, зөөх, засварлах, шаардлагатай бол энэ тухай эрх бүхий байгууллагын албан ёсны техникийн дүгнэлт (акт), шийдвэрийг архитектур төлөвлөлтийн даалгаварт хавсаргах.

**Анхааруулга:**

Барилга, байгууламжийн зураг төслийг боловсруулахдаа АТД-т заасан нэр, зориулалт, барилгын давхрын тоо, хэмжээнээс хэтрүүлсэн тохиолдолд эскиз зураг батлагдахгүй болно

**Боловсруулсан:**

Хот байгуулалтын кадастр, зураг төсөл, магадлалын асуудал хариуцсан мэргэжилтэн . . . .
. . . . . /Б.Буманбаатар/

ХОТ БАЙГУУЛАЛТЫН
КАДАСТРЫН МЭДЭЭЛЛИЙН
САНГИЙН ЦАХИМ СИСТЕМ

Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн Гүйцэтгэх захирлын
2022 оны 08 сарын 24-ны өдрийн
А/92 тоот тушаалын Хоёрдугаар хавсралт Маягт-9

MONGOLIA NETCOM
ӨНДӨР ХУРДНЫ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ

БАТЛАВ
МЭДЭЭЛЭЛ ХОЛБООНЫ СҮЛЖЭЭ
ХХК-ИЙН ДУНДГОВЬ АЙМГИЙН ГАЗРЫН
ДАРГА ..... Б.Өлзийбаяр

**ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ**

**Дугаар А-А4/2023**

/Аймгийн нэр:Дундговь аймаг/

2022 оны 05 сарын 09 өдөр

**Захиалагч байгууллага: Өндөршил сумын засаг дарга**

**Хэрэглэгчийн нэр: У.Алтанхүү**

**Харилцах утас:93177884**

**Байршил:Дундговь Өндөршил сум 3-р баг 113 тоот**

| Сувагчлалаар татах шилэн кабелийн хэрэгцээ: | | | | | |
|---|---|---|---|---|---|
| д/д | Кабель шугамын тасаг | Чиглэлийн нэр: | Сувагчлалын урт (м) | Худгийн тоо (ш) | Агаарын шилэн кабель (м) |
| 1 | | Өндөршил сумын одоо ашиглагдаж байгаа Эрүүл мэндийн төвөөс-шинээр баригдах | = | = | 100м |

**Нэмэлт тайлбар:** Хуучин эрүүл мэндийн төвийн холбооны техникийн өрөөнөөс шинээр баригдах эрүүл мэндийн төвийн техникийн өрөө хүртэл 12 соге агаарын шилэн кабель ашаараар татна. Шилэн кабелийн эхлэл төгсгөлд залгаа хийж цэнэглэнэ. Шинээр баригдах барилгын дээвэрт кабелын тавиур суурьлуулна. Дотор монтажны UTP кабелийг разетикуудад цэнэглэсэн байна.

**Техникийн онцгой нөхцөл:** Харилцаа Холбооны Зохицуулах Хорооноос хорооноос олгогдсон харилцаа холбооны үндсэн сүлжээ байгуулах эрхийнхээ дагуу техникийн нөхцлийг зөвхөн Мэдээлэл холбооны сүлжээ ХХК олгоно. Техникийн нөхцөлгүйгээр холбооны худаг сувагчлал байгуулах, кабель татах, шилжүүлэх тохиолдолд уг барилга обьектыг техникийн комисс болон улсын комиссоор хүлээн авахгүй болно.

**1.Техникийн үндсэн нөхцөл:**

1.1 Угсралт суурилуулалтын ажлыг Харилцаа Холбооны Зохицуулах Хорооноос олгосон холбооны кабель шугамын угсралт хийх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжээр гүйцэтгүүлнэ.

1.2 Худаг сувагчлалаар шинээр шилэн кабель суурилуулахдаа Монгол Улсын MNS 5207:2011, MNS 5278:2012, MNS 5317:2011 стандартуудыг мөрдөнө.

1.3 Угсралтын ажил эхлэхийн өмнө тус газрын харъяалагдах нэгжид мэдэгдэн ажил эхлэх зөвшөөрөл авна.

1.4 Техникийн нөхцлийн дагуу гүйцэтгэсэн ажлыг техникийн актаар хүлээлгэн өгөөгүй тохиолдолд түүнд гарах аливаа эрсдэл, гэмтэл саатлын хариуцлагыг Мэдээлэл холбооны сүлжээ ХХК хариуцахгүй болно.

1.5 Техникийн нөхцлийн дагуу худаг сувагчлалын түрээсийн гэрээ байгуулна.

**2. Угсралтын ажлын үед тавигдах шаардлага:**

2.1 Угсралтын ажлын явцад захиалагч ашиглалтын байгууллагатай хамтран хяналт тавьж, угсралтын технологийн шаардлагыг бүрэн хангуулсан байх.

2.2 Шилэн кабелийг худагт нөөц үлдээхгүй татах бөгөөд зөвхөн төгсгөлийн төхөөрөмж байрлуулах хэсэгт нөөц авахыг зөвшөөрнө.

2.3 Шинээр татсан кабельд биркийг /хаягжилт/ худаг бүрт болон төгсгөлийн төхөөрөмжид бүрэн хийсэн байх ба худагт кабелийн залгаа хийх тохиолдолд муфтыг худгийн хананд тусгай тавиур хийж байрлуулсан байх.

2.4 Кабелийг техникийн нөхцөлд заасан трассын дагуу татаагүй тохиолдолд ашиглалтын явцад гарах эрсдэлийг Мэдээлэл холбооны сүлжээ ХХК хариуцахгүй болно.

3. **Угсралтын ажил дууссаны дараа тухайн ажлыг AutoCAD-ын гүйцэтгэлийн зураг хийлгэж, тухайн ашиглалт хариуцсан газарт техникийн актаар хүлээлгэн өгнө.**

4. **Техникийн нөхцлийг Өндөршил сумын засаг даргын 2023 оны 04 сарын 24-ний өдрийн 1/107 тоот албан бичиг, хүсэлтийг үндэслэн олгов.**

5. **Энэхүү техникийн нөхцөл нь батлагдсан өдрөөс хойш 1 жилийн хугацаанд хүчинтэй байна. Техникийн нөхцлийн хугацаа дуусахаас 1 сарын өмнө сунгалт хийлгэх хүсэлт хүлээн авч, сунгах боломжтой.**

Хянасан:

/ Ерөнхий инженер /
..... /Г.Чанцалням/

Боловсруулсан:

/ Кабель шугамын инженер /
/М.Батсүх/

**Өндөршил сумын Эрүүл мэндийн төвийн гадна холбоожилтын зураглал**

**ДУНДГОВЬ АЙМГИЙН**
**"ИРМҮҮН ТҮШИГ" ХХК**
48090 Сайнцагаан сум, Дундговь аймаг

2023.05.10 № 14

танай _____ -ны № _____ -т

ӨНДӨРШИЛ СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗАРТ

Эрүүл мэндийн төвийн барилгад
дулааны техникийн нөхцөл олгох тухай

Өндөршил суманд баригдах Эрүүл мэндийн төвийн 10 ортой барилга, эмчийн байрыг дулааны шугамтай холбоход тус байгууллагын магистрал 108 шугамын 2 дүгээр худгаас 108 диаметрээр оготолгоо хийж ган бөмбөлөгөн шаариктай хаалтаар шугамаа лоткитэй хийхийг зөвшөөрч байна.

ЗАХИРАЛ Д.БАЯСГАЛАН

ДУНДГОВЬ АЙМГИЙН
ӨНДӨРШИЛ СУМЫН
ЗАСАГ ДАРГА
Төв-301, 3-р баг, Өндөршил сум,
Дундговь аймаг 48010 Утас: 93177884
Цахим хаяг: undurshil@dundgovi.gov.mn

2023.05.10 № 1/222

танай _____ -ны №_____ -т

# ТОДОРХОЙЛОЛТ

Тус суманд баригдах 10 ортой Эрүүл мэндийн төв, эмчийн байрны барилгын хэрэглээний усны хангамжийг ЗДТГ-ын эзэмшлийн халуун усны 1л/сек-ийн ундаргатай гүний худгаас хангах боломжтой.

ОНХС-ийн 2023 оны хөрөнгө оруулалтаар халуун усны дулааны шугамтай хамт Эрүүл мэндийн төвийн хуучин барилгын дулааны худаг хүртэл цэвэр усны шугам татахаар төлөвлөгдсөн тул хэрэглээний усыг 32 метрээс үргэлжлүүлэн татах боломжтойг тодорхойлов.

ОРЛОГЧ Л.МӨНХБАДРАХ

D:\My documents\ZD toot.docx

БАГАНУУР ЗҮҮН ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ТӨХИ... ДАХЬ САЛБАР

БЗӨБЦТС ТӨХИЙН ЗАВЬСҮМБЭР САЛБАРЫН
ДАРГА Б. БАТТУУЛ

**ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧЭЭР ХАНГАХ ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ**

2023 оны 05 дугаар сарын 11-ний өдөр №14/23 Говьсүмбэр аймаг

| | |
|---|---|
| **1.Техникийн нөхцөл хүссэн хуулийн этгээд болон байгууллага** | *Дундговь аймгийн Өндөршил Сумын засаг дарга У.Алтанхүү* |
| **2.Хэрэглэгчийн хаяг:** | *Дундговь аймаг, Өндөршил сум, 3-р баг, Бөхт төв* |
| **3. Хэрэглэгчийн байршил, зэрэглэл:** | *Дундговь аймаг, Өндөршил сум, 3-р баг, Бөхт төв, III зэрэглэл* |
| **4. Ажил үйлчилгээний зориулалт** | *Эрүүл мэндийн төв* |
| **5. Техникийн нөхцөл олгох үндэслэл:** | *Дундговь аймгийн Өндөршил Сумын засаг дарга У.Алтанхүүгийн 2023 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн техникийн нөхцөл хүссэн албан тоот, холбогдох бичиг баримт* |
| **6. Суурилагдсан чадал:** | *15 кВт* |
| **7. Холбогдох цэг:** | *7.1 Дундговь аймаг, Өндөршил сум, 3-р баг, Бөхт төвд байрлах, Эрүүл мэндийн төвийн 380 В-ын цахилгаан хангамжийг 6/0.4 кВ АТП-81 дэд өртөөний 0.4 кВ-ын Ерөнхий щитийг өргөтгөж, шинээр гаргалгаа гарган 0.4 кВ-ын 50 мм$^2$-аас багагүй хөндлөн огтлолтой бүрээстэй СИП дамжуулагчтай цахилгаан дамжуулах агаарын шугамаар тэжээнэ* |
| **8. Тоолуур хэмжих хэрэгсэл:** | *8.1 Шинээр гаргаж, салбарлаж буй шугамын эхэнд ачаалалд тохирсон автомат ба стандартчлал хэмжил зүйн төвөөс загварын туршилтанд орж ашиглахыг зөвшөөрч баталгаажуулсан гурван фазын 3G, 4G сүлжээнд ашиглах боломжтой RS485 порт бүхий оролттой бүрэн ухаалаг тоолуур монтажилж, щитний хайрцаг суурилуулж тавина.*<br>*8.2 Кабелийг газраар 0.7 м-ээс багагүй ухсан шуудуугаар явуулах ба үзүүрүүдэд төгсгөвч, орчин үеийн шинэ технологитой муфть хийж холбох ба галын аюулгүй байдлыг хангаж, угсарна.* |
| **9. Тусгай заалтууд:** | *9.1 Хэрэглэгчийн баригдах объект нь бусдын эзэмшлийн газар нутаг, инженерийн байгууламжийг дайрч байвал холбогдох эзэмшигчээс зөвшөөрөл авна. Мөн объектын хамгаалалтын зурвас, газрын зөвшөөрлийн талаар холбогдох албан газраас нь зөвшөөрөл авна.*<br>*9.2 Шинээр хийгдэх цахилгаан угсралт, монтажийн ажилд хүчдэлийн түвшингийн ±5%-ийн хэлбэлзэлд ажиллах, Монгол орны цаг уурын нөхцөлд зохицсон, экологид сөрөг нөлөөлөлгүй орчин үеийн шинэ найдвартай тоног төхөөрөмж суурилуулна.*<br>*9.3 Цахилгааны оруулга, гаргалгааны кабель шугам, барилгын дотор монтаж, угсралтын ажлыг "Эрчим хүчний барилга байгууламж барих* |

Scanned with MOBILE SCANNER

*тусгай зөвшөөрөл"-тэй мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ.*
***9.4** Шинээр баригдах шугам тоноглолын барилга угсралтын ажлыг норм дүрмийн дагуу гүйцэтгэж, шаардлагатай туршилт хэмжилтийг "БЗӨБЦТС" ТӨХК-иар хийлгэж, холбогдох хүчин төгөлдөр акт, протоколыг бүрдүүлнэ.*
***9.5** Техникийн нөхцөлд тусгагдсан эрчим хүчний барилга угсралтын ажлыг гүйцэтгэсний дараа "Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм"-ийн 4.22, 4.23-р заалт, БЗӨБЦТС ТӨХК-ийн "Цахилгаан түгээх сүлжээнд шинээр холбогдох объектыг ашиглалтанд хүлээн авах журам"-ын дагуу цахилгаан түгээх сүлжээнд холбогдоно.*
***9.6** Шинээр суурилагдах 380 В щитний хайрцагт "Цахилгаан байгууламжийн дүрэм"-ийн 1.6.41-н дагуу газардуулга хийх, газардуулгын эсэргүүцэл 4 Ом-оос ихгүй байхаар хийж гүйцэтгэнэ.*

**10. Дор дурдсан техникийн даалгавар, хууль дүрмийг мөрдөх:**

***10.1** Цахилгаан тоноглол болон кабель шугамын ашиглалт үйлчилгээний талаар БЗӨБЦТС ТӨХК–ийн Говьсүмбэр салбарын Шуурхай үйлчилгээний хэсэгтэй, цахилгаан эрчим хүчний тооцооны талаар Хангах үйл ажиллагааны хэсэгтэй тус тус гэрээ байгуулж ажиллана.*
***10.2** Хэрэглэгч нь Монгол улсын Эрчим хүчний тухай хуулийн 30.1.2 30.1.3 30.1.4 30.1.7 30.1.8-р заалтуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллана.*
***10.3** Хэрэглэгч нь "Эрчим хүчний тухай" хуулийн 30.1.10 дахь заалтын дагуу өөрийн эзэмшлийн цахилгаан тоног төхөөрөмжөөс бусад хэрэглэгчдийг тэжээх үүрэгтэй.*
***10.4** Цахилгаан эрчим хүч хэрэглэгч нь Монгол Улсын Эрчим Хүчний тухай хууль болон цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрмийн заалтуудыг дагаж мөрдөх үүрэгтэй.*
***10.5** Энэхүү техникийн нөхцлийн дагуу барилга угсралтын ажлыг нэг жилийн хугацаанд хийж гүйцэтгэн сүлжээнд холбогдох бөгөөд энэ хугацаанд ажлыг хийгээгүй тохиолдолд дахин шинээр техникийн нөхцөл авна.*
***10.6** Хэрэглэгч нь "Эрчим хүчний тухай" хуулийн 32.3.2, 32.3.3 дахь заалтуудын дагуу цахилгаан эрчим хүч хэрэглэх техникийн нөхцөлийг зөрчсөн, гэрээгээр заасан цахилгаан чадлыг хэтрүүлсэн тохиолдолд цахилгаан эрчим хүчээр түдгэлзүүлнэ.*

ХЯНАСАН:

ТҮГЭЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА ХАРИУЦСАН МЕНЕЖЕР, ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР — Ё.БОЛДБААТАР

ХАНГАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА ХАРИУЦСАН МЕНЕЖЕР — Б.ЭНХЖАРГАЛ

БОЛОВСРУУЛСАН:

АШИГЛАЛТ ЗАСВАРЫН ИНЖЕНЕР — Э.БАТЦООЖ

Scanned with MOBILE SCANNER